

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРААС 2019 ОНЫ ДӨРӨВДҮГЭЭР
САРД ХИЙХ ҮНДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
2019.03.26-2019.04.25**

2019 оны 04 сарын 26-ны өдөр

Даланзадгад сум

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин	Хариуцах нэгж, албан хаагч	Биелэлт	Үнэлгээ хувиар	
						Нэгж	ДШДАХ
1	2	3	4	5	6	7	8
1.	Виз зөвшөөрлийн чиглэлээр	Монгол Улсад байх хөрөнгийн баталгаагүй, визийн ангиллаас өөр зорилгоор ирж буй гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрүүлэхгүй буцаах арга хэмжээ авч, буцааж буй үндэслэлийг тодорхой бүрдүүлэн, бүртгэл хөтлөж ажиллах.	Улсын хилээр нэвтрүүлэхгүй буцааж буй үндэслэл тодорхой байна.	Виз зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн, хяналтын улсын байцаагч нар	Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтоор Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, “Монгол Улсын виз олгох журам”-ын 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 11 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан. Тайлант хугацаанд 63 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 3 иргэний хасалт хийж ажилласан байна.		
		Виз, урилга олголт, визийн шилжүүлэг, түр болон удаан хугацаагаар ирэгчийн бүртгэл, хасалт хийлгэх талаар гадаадын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийг шуурхай хуулийн дагуу шийдвэрлэн, бүртгэл хөтлөж мэдээллийн санд баяжилт хийх.	Хуулийн дагуу хийгдсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар	Нийт 7 гадаадын иргэнд виз олгож, визийн хуудасны үнэ болох 56.470 /тавин зургаан мянга дөрвөн зуун далан/ төгрөгийг Гадаадын иргэн, харьяатын газрын Голомт банкны 1320000114 тоот дансанд, тэмдэгтийн хураамжийн 550.000 /таван зуун тавин мянган / төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын 100111600941 тоот дансанд тус тус тушаалган ажилласан болно.		
2.	Хяналт шалгалтын чиглэлээр	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулах.	Удирдамж батлуулж, холбогдох хууль тогтоомжийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар	Тайлант хугацаанд төлөвлөгөөт 1 удаагийн хяналт шалгалтыг зохион байгуулж, шалгалтад 12 аж ахуйн нэгж, байгууллагын 101 гадаадын иргэн хамрагдсан байна. Үүнд, тус газрын даргын 2019 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн баталсан ӨМ-2019/02		

1	2	3	4	5	6	7	8
2.	Хяналт шалгалтын чиглэлээр	Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг зохион байгуулах.	Удирдамж батлуулж, холбогдох хууль тогтоомжийн хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар, мэргэжилтэн нар	тоот удирдамжийн хүрээнд 04 дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Гурвантэс, Баяндалай, Ноён, Номгон сумдын нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт, ашигт малтмал, хайгуул, нүүрс тээвэр болон зам ангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 12 аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж буй БНХАУ, Австрали Улс, БНИндонез Улсын нийт 101 иргэний баримт бичигт хяналт шалгалт хийсэн бөгөөд зөрчил илрээгүй болно. Үнэт чулуу болон авто зам, гүүр барих, засвар тохижилтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 2 аж ахуйн нэгжид одоогийн байдлаар хөдөлмөр эрхэлж буй гадаадын иргэн байхгүй болно.		
3.	Албадан гаргах чиглэлээр	ГИЭЗБТХ зөрчсөн гадаадын иргэдийг Монгол Улсаас албадан гаргах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэх.	Холбогдох хуулийн дагуу шийдвэрлэсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, байцаагч нар	Тайлант хугацаанд албадан гаргасан гадаадын иргэн байхгүй болно.		
4.	Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр	1.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, анхан шатны баримтын бүрдлийг ханган ажиллах.	Төсвийг үр дүнтэй зарцуулсан байх.	Нягтлан бодогч Нярав	Энэ оны эхний 04 сард нийт 121,564,400 төгрөгний санхүүжилт авч 18 албан хаагчийн цалинд өссөн дүнгээр 33,566,331.94 төгрөгийг олгож, нийгмийн даатгалын шимтгэлд 8,738,646.72 төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 6,856,632.80 төгрөг, дотоод албан томилолтын зардалд 807,000 төгрөг, хангамж бараа материалын зардалд 8,297,816 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,797,000 төгрөг, урсгал засварын зардалд 1,793,100 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.		

1	2	3	4	5	6	7	8
		<p>2.Албан хаагчдын цалин хөлс, байр ашиглахтай холбоотой зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал засвар бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, ажил олгогчоос олгох тэтгэмж тусламж зэргийг хууль тогтоомжид заасны дагуу зарцуулах.</p>	<p>Төсвийг үр дүнтэй зарцуулсан байх.</p>	<p>Нягтлан бодогч Нярав</p>	<p>Тус газрын 2019 оны 03 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан бөгөөд 1 дүгээр улирлын төлөвлөгөөний биелэлтийг Санхүү, хангалт үйлчилгээний газар, Хяналт-шинжилгээ, дотоод аудит, орон нутгийн хэлтэст хүргүүлсэн.</p>		
		<p>Төсвийн гүйцэтгэлийн мэдээ тайлан, үнэт цаасны тооцоо, авто машин ашиглалтын болон шатах тослох материалын тооцоог үнэн зөв гаргаж, холбогдох журмын дагуу тогтоосон хугацаанд тайлагнах.</p>	<p>Тайлан тооцоо хугацаандаа хүргэгдсэн байх.</p>	<p>Нягтлан бодогч Нярав</p>	<p>Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 02-ны дотор гаргаж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан төв санхүүд хүргүүлэн ажилласан. Тус газрын энэ оны 1 дүгээр улирлын төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг хуулийн хугацаанд тайлагнаж, хянан баталгаажуулж Санхүү, хангалт үйлчилгээний газарт 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр хүргүүлэн ажилласан болно. 2019 оны 03 дугаар сарын үнэт цаасны зарцуулалтын тайланг хяналтын улсын байцаагч, шатах тослох материалын зарцуулалтын тайланг жолооч нартай тооцоо нийлж хүлээн аван, тулгалт хийж нэгтгэн тооцоог үнэн зөв гаргаж энэ сарын 02-ны өдрийн дотор Санхүү, хангалт үйлчилгээний газарт хүргүүлж ажилласан.</p>		
		<p>Авто машины ашиглалт, хяналт, техникийн бүрэн бүтэн байдал, жолоочийн хариуцлага, ур чадварт хяналт тавьж ажиллах.</p>	<p>Автомашины ашиглалт хамгаалалтад хяналт тавин ажиллаж аюулгүй байдал хангагдсан байна.</p>	<p>Нярав</p>	<p>Газрын албан хэрэгцээнд ашиглагдаж буй автомашинуудын хяналт бүртгэлийг тухай бүр хийн, шаардлагатай сэлбэг хэрэгслийг худалдан авч тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдалд анхаарч ажилласан. Тухайлбал, тус газрын албан хэрэгцээнд ашиглаж буй Ланд круйзер 76 автомашины моторын тос масло, агаар шүүгч, тосны шүүрийг солиулж ажилласан.</p>		

1	2	3	4	5	6	7	8
5.	Захиргаа, хүний нөөц, сургалтын чиглэлээр	Байгууллагын даргын батлан гаргасан тушаал, дээд газраас ирүүлсэн журам, шийдвэрийг тухай бүр албан хаагч нарт танилцуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах.	Тушаал шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Байгууллагын даргын 3 тушаал, шийдвэрийг нийт албан хаагчдад танилцуулж ажилласан. Мөн төв газраас ирүүлсэн хариутай албан бичгийг холбогдох албан хаагчдад шилжүүлэн хариуг тухай бүр нь хүргүүлэн ажилласан болно.		
		Албан хаагчдын сарын цагийн тооцоо гаргах, төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварын нэмэгдлийн саналыг дээд газарт хүргүүлэх.	Албан хаагчдын цалин хөлс хугацаандаа олгогдсон байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Боомтод ажиллаж буй албан хаагчдын цагийн тооцоог хүлээн авч нэгтгэн ахлах нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн бөгөөд төрийн үйлчилгээний 6 албан хаагчийн 04 дүгээр сарын ур чадварын нэмэгдлийг олгож ажилласан.		
		Баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах.	Хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Тус газарт ирсэн нийт 13 албан бичгийг цаасан болон цахим хэлбэрээр бүртгэж, бүртгэл-хяналтын карт хөтлөн, газрын даргад танилцуулан, холбогдох албан хаагчид шилжүүлэн шийдвэрлэлтийн явцад хяналт тавин ажиллаж байна. 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар нийт ирсэн 13 албан бичгийн хариутай 4 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлэн ажилласан.		
		Иргэн, аж ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл, гомдол хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлүүлэх.	Өргөдөл гомдлыг хүлээн авч бүртгэх, хуульд заасан хугацаанд шийдвэрлэсэн байх.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Иргэн аж, ахуйн нэгж байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдол хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь шийдвэрлэн ажиллаж байна. Тус газарт 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар албан хаагчаас ирүүлсэн 3 өргөдлийг хүлээн авч бүртгэн хугацаанд шийдвэрлэн ажилласан болно. Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол байхгүй болно.		
		Тус газарт ирсэн, явсан албан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл, гомдлыг цахим хэлбэрт оруулах.	Газрын ирсэн, явсан бичиг, газрын даргын тушаал, өргөдөл гомдлыг скайнердан цахим хэлбэрт оруулж, архив	Захиргааны ахлах мэргэжилтэн	Тайлант хугацаанд тус газарт ирсэн нийт 13, явсан 4 албан бичгийг скайнердаж цахим хэлбэрт оруулж, байгууллагын и-оффис програмд бүртгэн ажилласан.		

1	2	3	4	5	6	7	8
5.	Захиргаа, хүний нөөц, сургалтын чиглэлээр		үүсгэсэн байна.				
		Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын албан хаагчдын виз олголт, бүртгэл, хасалт, торгууль зэрэг үйл ажиллагааны баримт бичгийн бүрдэл, тушаал, заавар, албан даалгавар болон бусад баримт бичгийн биелэлтийг шалгаж, засах, шаардлагатай сургалт, зааварчилгаа өгөх.	Хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн	Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх зорилгоор тус газрын хариуцан ажиллаж буй Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын албан хаагчдын виз олголт, бүртгэл, хасалт, торгууль зэрэг үйл ажиллагааны баримт бичгийн бүрдэл, тушаал, заавар, албан даалгавар болон бусад баримт бичгийн биелэлт, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд энэ оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 03, мөн сарын 19-ний өдрөөс 22-ны өдрүүдэд шалган туслах үйл ажиллагааг зохион байгуулж заавар зөвлөгөө өгч ажиллалаа.		
		Байгууллагын даргын 2019 оны А/101 дугаар тушаалын дагуу газрын мэдээллийн самбаруудыг шинэчлэх.	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, Захиргааны ахлах мэргэжилтэн Ахлах нягтлан бодогч	Газрын төв болон Гашуунсухайт, Шивээхүрэн боомт, Баянхонгор аймаг дахь мэдээллийн самбарын мэдээллийг тухай бүр шинэчлэн байршуулж иргэдийг мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.		
		Албан хаагчдад англи хэлний сургалтыг зохион байгуулах.	Албан хаагчдын хэлний мэдлэг дээшилсэн байна.	Захиргааны ахлах мэргэжилтэн	Тус газар нь Өмнөговь аймгийн Насан туршийн боловсрол төвтэй хамтран албан хаагчдад англи хэлний сургалтыг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч тус аймагт англи хэлний олимпиад зохион байгуулах, элсэлтийн шалгалтад бэлтгэхэд тус төвийн багш нарыг оролцуулах шаардлагаар сургалтыг хойшлуулаад байна.		
	Нийт албан хаагчдын дунд 10 хурууны шивэлтийн уралдаан зохион байгуулах.	Уралдаан зохион байгуулж, албан хаагчдын ур чадвар дээшилсэн байна.	Хяналтын улсын ахлах байцаагч, Сүлжээний инженер	Нийт албан хаагчдыг уралдаанд хамруулах зорилгоор тайлант хугацаанд албан хаагчид сургалтын чөлөөтэй, хяналт шалгалтын ажил зохион байгуулсан, төв газарт сургалтад хамрагдах ажлууд давхцсан тул 10 хурууны шивэлтийн уралдааныг 05 дугаар сард зохион байгуулахаар			

1	2	3	4	5	6	7	8
					хойшлуулсан болно.		
6.	Мэдээллийн технологийн чиглэлээр	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагааг хэвийн хангаж ажиллах.	Сүлжээний тасралтгүй үйл ажиллагаа хэвийн хангагдсан байна.	Сүлжээний инженер	Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган ажиллаж байна. Бүсийн хэмжээнд гарсан 5 эвдрэл, гэмтлийг тухай бүр нь засч сайжруулан ажилласан. Тус газар нь Гашуунсухайт, Шивээхүрэн боомтыг хариуцан ажилладаг бөгөөд хилийн боомт дахь албан хаагчдын ажлын цаг бүртгэлийн төхөөрөмжийн суурилуулалт, холболтыг хийж ажилласан.		

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР